

Гэрлэлт, гэр бүлийн асуудлаархи

зарим философи үзэл

Д.Тунгалаг – МУИС.НШУС.Философийн тэнхмийн багш, доктор, дэд проф

Түлхүүр үг: Гэрлэлт, гэр бүл, нийтлэг гэр бүл, моногам гэр бүл, патриархал үзэл, жам ёсны эрх, эзэмшлийн юм, гэрлэлтийн гэрээ, нэгдлийн тухай онол, хүйсийн ялгаа.

Философчид гэрлэлт, гэр бүлийн асуудлыг тухайлан авч үзээгүй ч анхаарлын гадна орхиогүй юм. Тухайлбал, эртний грекийн философич Платон, Аристотель, Аристип, Эпикур нар гэр бүлийн мөн чанар, гэр бүлийн жам ёсны асуудлыг өөр өөрийн байр сууринаас тайлбарлаж иржээ. Гэр бүлийн асуудлыг анх удаа онцлон авч үзсэн хүн бол эртний грекийн философич Платон юм. Платон гэр бүлийн талаархи үзлээ “Төр улс” зохиолдоо нилээд өвөрмөц байдлаар илэрхийлсэн бөгөөд “гэр бүл бол нийгмийн анхдагч үүр, өөрчлөгдөшгүй зүйл бөгөөд гэр бүлүүдийн нэгдлийн үр дүнд төр улс бий болсон” гэж бичжээ.

Гэвч Платон гэр бүлийг дэмжих үзэх үзлийг тууштай баримтлагч байгаагүй төдийгүй “төгс төгөлдөр төр”-ийг бий болгохын тулд эхнэр хүүхэд, эд хөрөнгийг нийтийн болгох үзэл санааг баримталж байв. Түүний үзэл санааны гол нь нийгмийн тэгш байдлыг тогтооход эд хөрөнгө, хувийн амьдрал, гэрийн аж ахуй, гэр бүл, хувийн баяр цэнгэлээс татгалзах явдал байв. Учир нь тэрээр өөрийн гэр оронтой, эхнэр хүүхэдтэй байх явдал хувийн бодох сэтгэлийг төрүүлдэг, эхнэр нөхөр хэмээх хосоос бүрэлдсэн гэр бүлд санаа зовох зүйл их байдаг. Иймээс “эхнэр хүүхэд ч нийтийн, эд хөрөнгө ч мөн нийтийн байх нь зүйтэй”² гэсэн байр суурийг хатуу баримтлаж байв. Түүнийхээр **нийтлэг гэр бүл** нь нийгмийн болон хувийн ашиг сонирхолыг нэггэж чаддаг хамгийн шудрага зохион байгуулалт юм. Нэгэнт тэдний орон байр, хоол унд нийтийнх болохоор хэн ч түүнийг өмчлөхгүй...хүүхдийг хүүхэд асрах газар луу аваачна, гэхдээ тэдний хэн ч өөрсдийнхөө хүүхдийг таньж чадахааргүй байх бүхий л аргыг хэрэглэх нь зүйтэй”³ гэж үзэж байв. Иймээс Платоны “бие хүн хувийн амьдралын хэрэгцээ сонирхлыг төрийн ашиг сонирхолтой нийцүүлэх хэрэгтэй, *төгс төгөлдөр төрд моногам гэр бүл огт шаардлагагүй*” гэсэн үзэл нь түүний гэр бүлийн талаархи үзэл санааных нь гол үндэслэл болж байв. Мөн Платоны нэгэн адил байр суурь баримталж байсан хүн бол эртний грекийн түүхч Геродот. Тэрээр “Түүх” гэдэг алдарт бүтээлдээ “бүх нийтийн эмэгтэйчүүд гэдэг бол зарим овог аймгийн бусдаас ялгарах онцлог юм”¹ гэж бичиж байлаг. Иймэрхүү үзэл санаа эртний грекийн сэтгэгчдийн үзэл санаанд нилээд илэрч байжээ.

Харин Аристотель патриархал гэр бүлийн тухай, “төгс төгөлдөр төр”-ийн тухай Платоны үзлийг шүүмжилж, гэр бүл бол сууринг /селение/ бий болгодог бөгөөд суурингуудын нэгдэл нь төр юм² гэжээ. Тэрээр “Никомаховын ёс зүй” гэдэг зохиолдоо гэр бүлд эхнэр нөхрийн харилцаа чухал болохыг тэмдэглээд “эхнэрээ хайрлах нөхрийн хайр нь бие махбодийн харилцаанд үндэслэгддэг. Гэр бүл нь төрөөс өмнө бий болсон гэдэг утгаараа байгаль нь хүнийг төрийн харилцаанд

¹ Платон. Законы. Соч. в 3 т. М. 1972. т. 3. ч. 2. с. 148-150.

² Платон. Соч. в 6-х т. М., 1971. т. 3. с.254.

³ Платон. Төр улс. УБ. 2005. 124, 126 дахь тал.

¹ Геродот. История. Л. 1972. С. 232.

² Аристотель. Этика, Политика, Риторика, Поэтика, Категории. Минск. 1998. С. 412-413.

гэхээсээ илүү гэр бүлийн харилцаанд илүү ойр бүтээж өгсөн. Хүн нь амьтны адил үр удмаа үлдээх төдийгүй амьдралыг бүхэлд нь бий болгохын тулд гэр бүлийн харилцааг бий болгодог. Гэр бүл дэх эхнэр нөхрийн үүрэг нь харилцан адилгүй боловч бие биенийгээ нөхдөг. Ингэснээр гэр бүлийн харилцаа нь өөртөө таатай бөгөөд ашигтай /хэрэгтэй/ зүйлсийг агуулдаг гэжээ. Тэрээр цааш нь үр хүүхэд гэдэг бол тэднийг холбож өгдөг чухал хүчин зүйл болохыг тэмдэглээд "гэр бүл нь нийгмийн харилцааны анхны хэлбэр, нийгмийн бүтцийн салшгүй элемент бөгөөд гэр бүл нь хувь хүний энгийн цуглуулга биш, харин гишүүн бүр давтагдашгүй онцлог чанартай, нэгдмэл зорилгыг агуулсан нийгмийн бүлэг мөн"³ хэмээн бичжээ. Ийнхүү **гэр бүлийн бие даасан шинжийг** хүлээн зөвшөөрч, түүнийг нийгмийн нэг бүлэг болгож үзсэнээрээ Платоноос давуу талтай юм.

Аристотелийн философи дахь гэр бүлийн асуудлаархи анхаарал татсан үзэл нь *засаглалын тухай ойлголт* юм. Тэрээр "Политика" хэмээх зохиолдоо өрх гэрт засаглалын гурван элемент⁴ байдаг гэж үзээд, нэг талаас, эр хүн эхнэр хүүхдээ өөрийн юмс гэдэг утгаар, нөгөө талаас, гэр бүлийн хүрээн дэх засаглалыг улс төрийн засаглалтай харьцуулан үзэж, энэхүү засаглал нь эзэн хүнээс боолтойгоо харилцах харилцаанд, эцэг хүнээс хүүхдүүдтэйгээ харилцах харилцаанд, нөхрөөс эхнэртэйгээ харилцах харилцаанд илэрдэг. Тухайлбал, нөхрийн эхнэрээ захирч байгаа харилцааг улс төрийн засаглалтай, харин хүүхдүүдээ захирч буй харилцааг эзэн хааны засаглалтай харьцуулж болно гэжээ. Үүнийгээ тэрээр эцэг эх нь хүүхдүүдээ хайрладаг учраас, ахмад нь учраас захирдаг, ийм учраас хаадын засаглалд тооцогдож байгаа юм гэж тайлбарлажээ.

Аристотелийн философи дахь гэр бүл дэх засаглалын тухай үзэл санааг гэр бүлийн бүтэц, удирдлага зохион байгуулалтын хувьд нийгмийн бичил бүлэг болохыг үзүүлсэн загвар гэж эерэг талаас нь үзэж болно. Хэдийгээр Аристотелийн гэр бүлийн талаархи үзэл нь Платоноос алхам урагшилсан боловч эхнэр хүүхдийг "өөрийн юмс" гэж үзэх үзэл болон гэр бүлд засаглал тогтоох эрх нь нөхөрт байх ёстой гэсэн үзэл санаанууд нь эрэгтэй хүн гэр бүлд ноёрхох байр суурьтай байх ёстой гэсэн патриархал үзлийг баримтлагч болохыг харуулж байна.

Ийнхүү эртний грекийн философичдоос үүсэлтэй гэр бүлийн талаархи патриархал үзэл нь олон үеийн турш философчдын үзэл санааны онолын үндэслэл болж байсан төдийгүй нийгмийн үзэл санаанд хүчтэй ноёрхож байв. Тухайлбал, францын соён гэгээрүүлэгч Жан Жак Руссо "хамгийн эртний нийгмээс эхлээд бүх нийгэмд байсан цорын ганц зүйл бол гэр бүл юм. Хэрвээ гэр бүл хэрэгтэй гэж үзвэл улс төрийн нийгмийн ирээдүйн дүр зураг, эрх баригч нь эцэг, ард түмэн нь хүүхдүүдтэй төсөөтэй юм гэсэн нь гэр бүл дэх засаглалын хэлбэрийн тухай эртний грекийн философчдын үзэл санааг баримтлагч байсны тод илрэл юм.

Харин шинэ үеийн гэр бүлийн судалгаанд Дарвины үзэл санаа чухал нөлөө үзүүлсэн гэж судлаачид үздэг. Дарвинизмийн үзэл санааны нөлөөн дор швейцарийн түүхч И.Я.Бахофен, английн эрдэмтэн Ж.Ф.Мак-Ленан, америкийн судлаач Л.Г.Морган нар өөрийн бүтээлээ туурвижээ. Ийнхүү олон үеийн турш онолын үндэслэл болж байсан гэрлэлт, гэр бүлийн талаархи *патриархал үзэл* XX зууны эхэн үеэс өөрчлөгдөж гэр бүлийн судалгааны чиг хандлага агуулгын хувьд өргөжиж эхэлсэн.

³ Мөн тэнд. с. 437

⁴ Мөн тэнд.

Шинэ үеийн сэтгэгчид гэр бүлийн харилцаанаас нийгмийн харилцаа бий болдог гэж үзэн, гэр бүлээс төрд харилцах харилцаанд анхаарлаа хандуулж байсан боловч гэр бүлийг өөрийг нь харьцангуй бие даан хөгжих зүй тогтолтой нийгмийн онцгой институт болохыг нь тодорхойлоогүй.

Шинэ үеийн гэрлэлт гэр бүлийн асуудлаархи философийн түүхийн судалгаанд германы философич Кант, Фихте, Гегель нарын үзэл тодорхой байр суурь эзэлдэг. Иймээс германы сонгодог философийн гол төлөөлөгчдийн өвийг судлах нь гэрлэлт, гэр бүлийн талаархи үзэл баримтлалд гарсан өөрчлөлтийг тодруулахад чухал ач холбогдолтой.

Кант, Фихте нар гэрлэлт, гэр бүлийн тухай асуудлыг авч үзэхдээ *жам /байгаль/ ёсны эрхийн* үзэл санааг үндэс болгосон байдаг. Түүний үзэл санаанд тухайн үеийн нийгэм-улс төрийн байдал тодорхой хэмжээгээр нөлөөлсөн бөгөөд харин ингэж шийдвэрлэх арга зүйн үндэс нь хувийн өмч мөнх байх зарчим юм. Товчоор хэлбэл, гэрлэлт, гэр бүлийн талаархи Кантын жам ёсны эрхийн үзэл нь нэг талаас, түүний философи-ёс зүйн үзэлд, нөгөө талаас тухайн үеийн германы нийгмийн бодит харилцаанд үндэслэгдсэн болно.

Кант эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш бус эрхийн зайлшгүйг тайлбарлахдаа “бүр иргэншээгүй, соёлжоогүй байхдаа ч давуу тал нь ямагт эр хүний талд байсан...тэрхүү давуу тал нь хүчтэй тал руугаа тэмүүлж байдаг. Эрэгтэй нь гэртээ ямагт “захирангуй” байдаг бол эмэгтэй нь “гэрийн амьтан” мэт байдаг эмэгтэй хүн хэзээд иргэний хувьд бие хүн байгаагүй, өөрөөр хэлбэл, иргэний бие даасан байдлыг эзэмшээгүй хүн юм¹ гэжээ. Эндээс харахад Кантын “эр хүний гэртээ захирангуй байх” үзэл, Аристотелийн “гэр бүл дэх засаглалын” тухай ойлголт нь хэлбэрийн хувьд ялгаатай болохоос агуулгын хувьд ижил, патриархал үзлийн онолын үндэслэл болж байсан гэж үзэх үндэстэй

Тэрээр гэрлэлтийн асуудлыг авч үзэхдээ *амины юмаа өмчлөх эрхийн* үүднээс эмэгтэй хүнийг “*эзэмшлийн юм*”² гэж нэрлэсэн байна. Хэдийгээр Кант гэрлэгсэдийн харилцаа болон эд хөрөнгийн тэгш эрхийн тухай ярьдаг ч захирагч нөхөр нь эхнэртээ хууль тогтоодог гэсэн үзэл дээрээ хатуу зогсож үүнийгээ хууль ёсны зөв зүйтэй явдал гэж үзэж байв. Ингэж эхнэр нь нөхөртөө захирагдах ёстой гэсэн санаа нь нөхрийн талаас шууд хүчирхийлэх боломжийг үгүйсгээгүй гэсэнтэй утга нэг гэж ойлгож болно. Үүнд л Кантын ёс суртахууны императивтай нягт холбоотой эхнэр нөхрийн хоорондын эзэмшлийн юмсын шинж тодорч байгаа юм. Эндээс үзвэл, Кантын “эзэмшлийн юм”, Аристотелийн “өөрийн юм” хэмээх ойлголтууд, Кантын “захирагч нөхөр нь эхнэртээ хууль тогтоодог тухай” императив, Аристотелийн “гэр бүл дэх засаглалын тухай” ойлголтууд агуулгын хувьд ижил болох нь харагдаж байна. Эндээс патриархал үзэл санаа, гэр бүл дэх хүйсийн ялгааны ойлголтыг онолын хувьд үндэслэж өгсөн гэж үзэж болно.

Түүнчлэн Кант “Зан суртахууны метафизик” зохиолынхоо “Амины юмаа өмчлөх эрхийн тухай” гэсэн хэсэгтээ гэрлэлтийн асуудлыг авч үзсэн байна. Өөрөөр хэлбэл, Кант гэрлэлтийн асуудлыг амина юмаа өмчлөх эрхийн үүднээс буюу гаднын объектыг эд юмс мэт эзэмшиж, харин түүнийгээ хувийн юм шиг ашигладаг хувийн өмчийн үзэл санаанд тулгуурлан авч үзжээ. Тухайлбал, “хэрвээ эхнэр нөхрийн аль нэг нь нөгөөгөө хаяад явахад үлдсэн нь явсныгаа өмч мэт эргүүлэн авчрах бүрэн эрхтэй, үүний нэгэн адил гэрээсээ зугтсан хүүхдийг эцэг эх нь буцаах бүрэн эрхтэй” гэжээ. Кантын энэхүү эхнэр хүүхдийг өмч мэт эзэмших үзэл нь гэр бүлийн харилцаанд эрэгтэй эмэгтэйчүүдийн эзлэх байх суурийн ялгаатайг, гэр бүлд эрэгтэйчүүдийн эзлэх байр суурийн давуу

¹ И.Кант. Соч в шести томах, Т.6. М., 1966. С. 554.

² Мөн тэнд. Т.4, ч. 2, М., 1965. С. 286-287.

талыг илэрхийлдэг үзэл санааны үндэслэл болж байсан нь харагдаж байна. Үүнийг гэрлэлт, гэр бүлийн асуудлаархи Кантын императивын дутагдалтай тал гэж ойлгож байна.

Кант нь “үр удмаа үргэлжлүүдэг жам ёсны гэрлэлт” /албан ёсны гэр бүл ДТ/, “холбоо тогтож үл болох гэрлэлт” /албан ёсны бус гэр бүл ДТ/ хоёрын зааг ялгааг гарган тайлбарласан байдаг. Кант гэрлэлтийг зөвхөн үр удмаа төрүүлэхээр хязгаарлаагүй. Хэдийгээр байгалийн жам ёсоор хүүхэд төрдөг ч энэ нь хууль зүйн үндэс болж чадахгүй, иймээс гэрлэлтийг “гэрлэлт нь эрх зүйн гэрээ”-нд үндэслэгдэх ёстой гэж үзсэн. Гэхдээ Кант хууль эрхийн ойлголтыг оюун ухааны хуулийн хүрээнд авч үзсэн. Кантынхаар бэлгийн харилцаа нь байгалийн жам ёсонд суурилдаг бол хууль ёсны гэрээ нь оюун ухааны хуулиар тодорхойлогддог. Ингэснээр зайлшгүй байх ёстой хүйсийн жам ёсны харилцаа нь хүн төрөлхтний оюун ухаан болон эрх чөлөөнд тохирох харилцаа болон өөрчлөгдөнө гэсэн бөгөөд үүнийгээ Кант гэрлэлтийн “гэрээний харилцаа” хэмээн томъёолоод, гэрлэлт нь “хууль эрхийн хүрээнд цэвэр оюун ухаанд” зайлшгүй үндэслэгдэх ёстой гэж үзсэн. Кант гэрлэлтийг хуулийн хүрээнд авч үзэх нь ёс суртахуунлаг зүйл бөгөөд энэ нь зөвхөн моногам гэр бүлд хамаарах юм. Энэ нь гэр бүлийн эрх тэгш байдлын тухай жам ёсны эрхийн үзэлд бүрэн хариулт болох юм гэжээ. Ингэж гэрлэлтийн хууль ёсны болон ёс суртахууны үндэслэлийн зайлшгүйг гаргаж өгсөн нь Кантын үзэл санааны ололттой тал юм.

Түүнээс гадна “Эцэг эхийн эрхийн тухай” гэсэн хэсэгтээ Кант эцэг эх, үр хүүхдүүдийн хоорондын харилцааны асуудлаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ ёс суртахууны “хүлээсэн үүргийн” императиваар тайлбарласан байдаг. Тэрбээр жам ёсны эрхийг хүлээсэн үүргийн ёсоор гүйцэтгэх ёстой бөгөөд “хүүхдүүд эхлээд өөрөө бие даах чадвартай болтлоо эцэг эхээрээ тэтгүүлж байх эрхтэй. Үр хүүхдээ тэжээж тэтгэх нь эцэг эхийн хувьд ёс суртахууны үүрэг байх ёстой, тэд эцэст нь хүүхдүүддээ зарсан зардлаа нэхэх эрхгүй, харин зөвхөн тэдний талархалыг хүлээх ёстой”¹ хэмээн гэр бүлийн ёс суртахууны үүрэг хариуцлагын асуудлыг онцгойлон авч үзсэн нь түүний үзэл санааны нэг давуу тал юм. Гэхдээ Кант нийгэм, гэр бүлийн холбоог авч үзэхдээ гэр бүлийн ёс суртахууны болон эрх зүйг зохицуулах хэрэгслийг “төр зөвхөн хяналтын хүрээгээр хязгаарлагдана” гэдгээр тайлбарлаж байв. Кантын энэ үзэл санаанд тулгуурлан Фихте хүйсийн ялгааны тухай онолоо боловсруулсан.

Фихтегийн үзлээр, эмэгтэй хүн хуулийн этгээд биш учраас төрөөс эхнэрийнх нь өмч эзэмших эрхийг нөхөрт нь баталгаа гаргаж өгдөг. Эрэгтэй хүн эмэгтэй хүнийг бодвол мэдлэгийг оюун ухаанаар олж авдаг, иймд хүйсийн ялгаа нь биеийн хүчний адил оюун ухааны хүрээнд илэрдэг гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Үүнийгээ тодруулах зорилгоор Фихте дараах үндэслэгээг гаргасан байна. Байнга эцгийнхээ захиргаанд байдаг охин, нөхрийнхөө захиргаанд байдаг эхнэр, тэдний эрхийг хамгаалж байдаг нөхөр байж байхад тэрхүү эхнэр, охин хоёр төрийн эрхийг эдлэхийг хүсэх гэж үү? Эмэгтэй хүн эрхээ эдлэхээс татгалзана гэдэг нь түүний өөрийнх нь зан суртахууны зайлшгүй хүсэл юм. Эмэгтэй хүн өөрийн эрх чөлөөгөө эргүүлэн олж авч болно, гэхдээ оюун ухаандаа ухамсарласнаар тэрхүү эрх чөлөөг хүсэхгүй байж болно. Яагаад гэвэл түүний өөрийнх нь хүслээр нөхөр нь түүний бүх эрхийг захирч байдаг. Ингэснээр нөхөр нь эхнэрийнхээ нийгмийн халамжлагч нь болдог. Энэ нь эмэгтэй хүний нийгэмтэй харилцах харилцааны илрэл болдог. Хэрэв эмэгтэй хүн нийгмийн үйл хэрэгт өөрийн дуу хоолойгоо хүргэхийг хүсч байгаа бол өөрийнхөө нэр хүндийг унагахгүйн тулд дуу хоолойгоо нөхрөөрөө дамжуулан хүргэх ёстой гэжээ.

¹ Мөн тэнд. С.195.

Ийнхүү Фихте Кантын адил гэр бүлийг жам ёсны эрхийн үүднээс хүйсийн ялгааг тайлбарлахыг оролдсон байдаг. Ялангуяа хүйсийн ялгааны талаархи үзлээ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байгалаас заяасан зан төлөвийн ялгаагаар илэрхийлэгдэг гэж үзээд, хүйсийн байдлыг *идэвхитэй* ба *идэвхигүй* гэж ангилсан байна. Тухайлбал, эрэгтэй хүн бэлгийн дур хүслийг гол зорилгоо болгодог бол эмэгтэй хүн үгүй. Зорилго гэдэг утгаараа энэ нь эмэгтэй хүний байгалийн хуультай зөрчилддөг. Байгалийн хуулиар эмэгтэй хүн ичимхий байдаг бол эрэгтэй хүнд энэ нь заяагаагүй. Тийм болохоор эмэгтэй хүн нэр төрийн оргилд хүрэхийг эрмэлздэггүй. Ингэвэл ичиж зовох зүй ёсоо алдах болно. Ухаалаг, сайн эмэгтэй зөвхөн өөрийн нөхөр, хүүхдүүдээрээ бахархаж, тэдэндээ л шингэн уусч байдаг. Эрэгтэй хүний жам ёсны эрх нь байгалаас заяасан, түүнийгээ хангахыг эрмэлзсэн хүслээр илэрдэг бөгөөд үүгээрээ эсрэг хүйстнээ сонгох идэвхи гарна. Эр хүний хувьд сонголтын давуу тал нь Фихтегийнхээр хүн нисч чаддаггүйтэй адил тийм л жам ёсны, байгалаас заяасан зүйл юм гэжээ. Ингэж Фихте хүйсийн ялгааг байгалаас заяасан жам ёсны хууль гэгчээр үндэслэж энэхүү хүйсийн ялгааг гэр бүлийн харилцаан дээр ч хатуу баримтлах ёстой хэмээн үзэж үүнийгээ нотлохыг оролдсон байна. Эмэгтэй хүн итгэл алдвал гэр бүлийн харилцааг бүрмөсөн устгадаг, харин нөхөр нь итгэл алдвал тэр бүр устахгүй, эхнэр нь түүний энэ үйлдлийг өршөөж чаддагт байгаа юм. Хэрэв эхнэр нь гэрлэлтээ цуцлахыг хүсэхгүй байгаа бол түүнд төр оролцож эхнэрийг нь нэхрийн гэрээс гаргаж гэр орон нь өрхийн тэргүүн гэдэг утгаараа нөхөрт нь үлддэг гэжээ. Фихтегийнхээр эхнэрийн үнэнч бус байдал нь гомдсон нөхөрт нь салах үндэс болдог бөгөөд ингэснээр өмч хөрөнгө болон бусад асуудлыг нөхрийн талд ашигтайгаар шийдвэрлэж, харин үнэнч бус байдлын үр дагавар нь нөхрөөс нь илүү эхнэрт нь хүндээр тусдаг байна. Ийнхүү тэрээр зөвхөн зөвхөн эмэгтэйчүүдийг буруутган, үнэнч бус байх эрхийг эрэгтэй хүнд олгож байснаараа гэр бүл дэх хүйсийн тэгш бус байдлын үзэл санааны томоохон төлөөлөгч болох нь харагдаж байна.

Үүнээс гадна Фихтегийн философийн диалектик систем нь түүний гэрлэлт, гэр бүлийг үзэх үзлийн онолын үндэс нь болж байв. Тухайлбал, Фихтегийн анхны сэдэв нь эр хүн - *зүтгэгч хүйс* /деятельный пол/, эмэгтэй хүн - *үйлдэгдэх хүйс* /страдательный пол/ юм. Фихтегийнхээр үйлдэгдэх /зовох/ нь зүтгэгч /ажиллагаа/-ийн үгүйсгэл, өөрөөр хэлбэл, зүтгэгч ба зүтгэгч биш нь тезис ба антитезис юм. Эдгээрт окуны үйл ажиллагааны эролцоотойгоор эсрэг талуудыг нээж өгөх, тэдгээрийн нэгдлийг бий болгох хэрэгтэй. Зүтгэгч эр хүн болон үйлдэгдэх эмэгтэй хүний нэгдэл нь ёс суртахуунлаг хүн байх бөгөөд энэ нь дан ганц эр хүн буюу эмэгтэй хүн биш хожуулаа байх ёстой, "гэр бүл болоогүй хүн бол хагас /тал/ хүн" юм гэжээ. Ингэж Фихте ёс суртахуунлаг байхын үндэс нь эрэгтэй эмэгтэй хүний нэгдэл гэж үзсэнээрээ нэг талаар, гэр бүл бол хүн төрөлхтний оршихуйн үндэс, нөгөө талаар, хүнд зайлшгүй гэр бүлтэй болох ёс суртахууны шаардлага тавигддаг болохыг үндэслэсэн. Энэ нь Фихтегийн гэрлэлт, гэр бүлийн талаархи үзэл санааны ололттой тал юм. Нөгөө талаар, Фихтегийн энэхүү *нэгдлийн тухай онол* нь Кантын гэрлэлтийн гэрээний онолыг шүүмжлэх үндэслэл болжээ. Кант гэр бүлийг жам ёсны эрхийн хүрээнд тайлбарлахдаа гэрлэлтийг зөвхөн эрх зүйн гэрээ гэж үзэж байгаа нь хязгаарлагдмал, хангалтгүй байна гэж Фихте шүүмжилжээ. Фихтегийнхээр энэ нь юм • бүхэн эрх • гэдэг ойлголтоор тодорхойлогддогийн нэгэн адил гэр бүл нь эрх чөлөөт хүмүүсийн хамтын амьдрал гэдэг алдаатай ойлголтонд хүргэж болзошгүй юм. Хэрэв хамтын амьдрал нь ямар нэгэн эрхэм дээд зүйлд зохион байгуулагдаж, үндэслэгдэхгүй, харин хуулийн албадлагын оролцоотой байвал энэ нь тэнэг хэрэг болно гэжээ. Фихтегийнхээр "гэрлэлт нь зөвхөн хууль зүйн холбоо биш, харин төр-гэр бүл-жам ёсны ёс суртахуунт амьдралын холбоо юм.

Гагцхүү хүйс хоорондын жам ёсны харилцаанаас л ёс суртахууны хүмүүжил бий болж хүн төрөлхтөн сайн үйлд хүрнэ. Гэтэл бодит байдалд дээрхи байдлыг байгалийн эрхэм дээд зорилго гэж ухамсарлахгүй, харин зөвхөн өөрийнхөө энгийн хүслээр л хязгаарладаг гэж шүүмжилжээ.

Гэр бүлийн тухай Кант, Фихте нарын үзлээс Гегелийн үзэл өөрийн гэсэн онцлогтой. Хөгжлийн тухай үзэл, түүхэн үзлийн зарчим нь Гегелийн гэрлэлт, гэр бүлийг үзэх үзлийн үндэс болсон юм. Түүнийхээр гэр бүлийн гишүүн ба иргэн хэмээх хоёр ойлголт уг чанараараа эсрэг тэсрэг хоёр чанар гэж үзэн үүнийгээ хүн ба төрийн харилцааны үүднээс шинжилжээ. Үүнд бодгаль, гэр бүл хоёрын харилцаа хэдийгээр бүхэл, хэсэг хоёрын харилцаа боловч түүнийг бодгаль, ард түмэн хоёрын харилцаатай зүйрлэж болохгүйг анхаарах хэрэгтэй. Өрх гэрийн гишүүн бодгаль нь иргэн хэмээх бодгалиас өөр юм гэж үзсэн. Тэрээр эрхийн үүднээс гэр бүлд хандах Кантын үзлийг шүүмжилж байв. Энэ тухайгаа “Эрхийн философи” гэдэг зохиолдоо тодорхой гаргаж “гэрлэлтийг ч, төрийг ч гэрээний ойлголтонд багтааж болохгүй. Ингэх юм бол гэрлэлт нь харилцан тохиролцсон хэрэглээний гэрээ болж хувирна”¹ гэжээ. Угтаа гэрлэлтийг гэрээ гэж үзэж байсан Кант, энэ үзлийг шүүмжилж байсан Гегель нарын хооронд ялгаа байсан юм. Кант нь гэр бүлийг эрхийн үүднээс тайлбарлахдаа зөвхөн *гэрлэгсэдийн гэрээгээр* хязгаарлаж байсан бол Гегель *өмчийн харилцаанд* илүү ач холбогдол өгч байв. Иймээс Гегелийнхээр бодгалиудын эд хөрөнгийн харилцаа нь “цусан төрлийн” харилцаанаас илүү чухал холбоонд² оршдог болно. Хэдийгээр Гегель эрхийн чиглэл дэх онолын болон арга зүйн хэд хэдэн үндэслэлийг шүүмжилсэн боловч тэдгээрийн зарим нь түүний үзэл баримтлалд цааш хөгжсөн юм. Тухайлбал, Гегель гэр бүлийн мөн чанар нь нийгмийн зохион байгуулалтын нэг хэлбэр болох өмч гэж үзээд, “тэр нь өөрийн субстанцлаг бие хүний бэлэн ахуйгаа ямар нэг эд хөрөнгө мэтээр олно”³ гэж дурьдсан байдаг. Ийнхүү Гегель хүний амьдралын шинж төлөвийг гагцхүү хувийн өмчөөр хэмжиж, өмчөөс хамаарагдахгүй гэр бүлийн амьдрал байж болохгүй гэдэг байр суурь дээр бат зогсож байв. Хэдийгээр гэр бүлийг “жам ёсны эрх”-ийн үүднээс тайлбарлаж байсан Кант, Фихте нарын үзэл, гэр бүлийг өмчтэй холбон тайлбарлаж байсан Гегелийн үзэл баримтлалын хооронд ялгаа байсан хэдий ч Кантын *гэр бүл нь нийгмийн хөгжлийн анхдагч үүр* хэмээх томъёолол, Гегелийн *өмчийн тухай үзэл* нь цаашид марксист болон өрнөдийн эрдэмтэдийн онолын үндэслэл болж ном зохиолуудад түгээмэл хэрэглэгдэж иржээ.

Гэрлэлт, гэр бүлийн талаархи Гегелийн үзэл санаа нь Кант, Фихте нарын нэгэн адил эрэгтэй хүн хүчирхэг, идэвхитэй үйл ажиллагааны эхлэл болдог, харин эмэгтэй хүн идэвхигүй бөгөөд субъектив эхлэл болдог гэж үзэж байв. Гегель “хүйсийн жам ёсны тодорхой байдал”-ыг оюун ухааны ба зан суртахууны ялгаанд оршино, харин байгалийн ба оюун санааны ялгааны үр дагавар нь тэдгээрийн нийгэм болон гэр бүлд эзлэх байр суурийн ялгаагаар харагдана. Эмэгтэй хүний “субстанции утга” нь гэр бүлийн амьдрал байдаг бол харин эрэгтэй хүний “бодит субстанции амьдрал” нь төрийн болоод шинжлэх ухааны үйл ажиллагаанд илэрдэг гэснээрээ мөн л тухайн үеийн хүйсийн тэгш бус байдлыг баримтлагчдын нэг болох нь харагдаж байна. Иймээс тэрээр эмэгтэй хүнийг нийгмийн үйл ажиллагаанд оролцохыг эсэргүүцэж, эмэгтэй хүн төрийн эрхэнд гарвал санамсаргүй алдаа гаргаж ингэснээр төр хямрах, аюулд өртөх магадлалтай гэж үзсэн. Ийнхүү германы философчид эмэгтэй хүний нийгэм, гэр бүлд эзлэх байр суурь болон хүйсийн харилцааны асуудлыг жам ёсны эрхийн

¹ Гегель. Соч. в шести томах, т.4, 1959. С. 239.

² Мөн тэнд. С. 202.

³ Мөн тэнд.

үүднээс ялгаатай хэмээн үндэслэхийг оролдож байсан нь хожим үеийн хүйсээр ялгаварлах үзлийн онолын үндэслэл болж байсан гэж үзэх үндэстэй.

Ашигласан ном

1. Аристотель. Этика, Политика, Риторика, Поэтика. Минск. 1998.
2. Аристотель. Никомаховын ёс зүй. УБ. 2008 он.
3. Гегель. Соч. в шести томах, т.4, 1959.
4. И.Кант. Соч в шести томах, Т.6. М., 1966.
5. Платон. Соч. в 6-х т. М., 1971.
6. Платон. Төр улс. УБ. 2005 он.